Шувууны томуу өвчний тохиолдол, тархалтын нэгдсэн мэдээ

2017.01.01-нээс 12.31

2017 онд Дэлхийн улс орнуудад шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусын хүний өвчлөл **(4)**, зэрлэг болон тэжээвэр шувуудын дундах өвчлөл **(146565)**, А (H7N9) вирусын хүний өвчлөл **(756)** тус тус бүртгэгдсэн бол А (H5N6) вирусын хүний өвчлөл нэмж бүртгэгдээгүй байна.

НЭГ. 2017 онд бүртгэгдсэн шувууны томуугийн А (H5N1) вирусын хүний өвчлөлийн тохиолдол ба нас баралт:

2017 онд шинээр Дэлхийн хоёр улсад өндөр хоруутай шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусийн хүний өвчлөлийн 4 тохиолдол бүртгэгдсэнээс 2 нь нас барсан байна.

Тохиолдол 1.

Египет улсын Menia хотын оршин суугч 4 настай эрэгтэйд 2017 оны 2-р сарын 02-ны өдөр өвчний шинж тэмдэг илэрч, 2-р сарын 10-нд эмнэлэгт хэвтээд 2-р сарын 20-нд эдгэрч эмнэлгээс гарсан. Халдварын эх уурхай нь гэр бүлийн гишүүд шувуутай харьцдаг байсан.

Тохиолдол 2.

Египет улсын Fayoum хотын оршин суугч 48 настай эрэгтэйд 2017 оны 2-р сарын 10-ны өдөр өвчний шинж тэмдэг илэрч, 2-р сарын 15-нд эмнэлэгт хэвтсэн. Халдварын эх уурхай нь үхсэн шувуутай харьцснаас халдвар авсан.

Тохиолдол 3.

Египет улсын Каир хотод оршин суугч 35 настай эрэгтэйд 2017 оны 4-р сарын 8-нд өвчний шинж тэмдэг илэрч 4-р сарын 16-нд эмнэлэгт хэвтсэн. Халдварын эх уурхай нь амьд шувууны аж ахуйн шувууны ялгадасаас халдвар авсан.

Тохиолдол 4.

Индонези улсын харъяат хүүхэд (нас тодорхойгүй), эрэгтэй, 2017 оны 9-р сарын 01-ний өдөр өвчний шинж тэмдэг илэрч, 9-р сарын 5-нд болон 10-нд тус тус эмнэлэгт хэвтсэн. Халдварын эх уурхай нь гэр бүлийн шувууны аж ахуйгаас халдвар авсан.

2003 оноос 2017 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд дэлхийн 16 улсад шувууны томуугийн А (H5N1) вирусийн 860 тохиолдол бүртгэгдсэнээс 454 (52.7%) нь нас барсан (График 1).

Номхон далайн баруун бүсийн улс (*Камбожи, *Хятад, *Лаос, *Вьетнам)-д 2003 оноос хойш 238 тохиолдол бүртгэгдсэнээс 134 (57%) нь нас барсан ба Камбожи улсад нас баралтын түвшин хамгийн өндөр (66%; 37/56) байсан бол 2017 онд эдгээр улсад шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусын халдвар бүртгэгдээгүй байна (Хүснэгт1).

Хүснэгт 1. ДЭМБ-д мэдээлэгдсэн томуугийн А (H5N1) вирусын халдварын хүний өвчлөлийн тохиолдол, нас баралт, бодит тоогоор, 2003 – 2017.12.31

№	Улс	2003-2010		2011-2015		2016		2017		Нийт	
		Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н
1	Азербайжан	8	5	0	0	0	0	0	0	**8**	**5**
2	Бангладеш	1	0	7	1	0	0	0	0	**8**	**1**
3	*Камбожи	10	8	46	29	0	0	0	0	**56**	**37**
4	Канад	0	0	1	1	0	0	0	0	**1**	**1**
5	*Хятад	40	26	13	7	0	0	0	0	**53**	**31**
6	Жибути	1	0	0	0	0	0	0	0	**1**	**0**
7	Египет	119	40	225	76	10	3	3	1	**359**	**120**
8	Индонези	171	141	28	26	0	0	1	1	**200**	**168**
9	Ирак	3	2	0	0	0	0	0	0	**3**	**2**
10	*Лаос	2	2	0	0	0	0	0	0	**2**	**2**
11	Мьянмар	1	0	0	0	0	0	0	0	**1**	**0**
12	Нигери	1	1	0	0	0	0	0	0	**1**	**1**
13	Пакистан	3	1	0	0	0	0	0	0	**3**	**1**
14	Тайланд	25	17	0	0	0	0	0	0	**25**	**17**
15	Турк	12	4	0	0	0	0	0	0	**12**	**4**
16	*Вьетнам	119	59	8	5	0	0	0	0	**127**	**64**
Нийт		516	306	330	143	10	3	4	2	**860**	**454**

* Номхон далайн баруун бүсийн улс

Тэмдэглэгээ: (**Т**)-тохиолдол; (**Н**)-нас баралт

График 1. ДЭМБ-д мэдээлэгдсэн шувууны томуугийн А (H5N1) вирусын хүний өвчлөл, улсаар

2003 – 2017.12.31



* Номхон далайн баруун бүсийн улс

ХОЁР. Шувууны томуугийн А (H5N6) вирусын хүний өвчлөлийн мэдээлэл:

2014 оноос хойш Дэлхийд шувууны томуугийн А (H5N6) вирусын хүний өвчлөлийн нийт 16 тохиолдол бүртгэгдсэнээс 6 (37.5%) нь нас барсан байна.

2017 оны 01-р сарын 01-нээс 12-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд шувууны томуугийн А (H5N6) вирусын хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** нэмж бүртгэгдээгүй байна.

ГУРАВ. Шувууны томуугийн А (H7N9) вирусын хүний өвчлөлийн мэдээлэл:

2013 оноос 2017 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд дэлхийн улс оронд шувууны томуугийн А (H7N9) вирусын нийт 1565 тохиолдол бүртгэгдсэн байна.

2017 оны 01-р сарын 01-нээс 12-р сарын 31-ний хүртэлх хугацаанд шувууны томуугийн А (H7N9) вирусын хүний өвчлөлийн **(756) шинэ тохиолдол** нэмж бүртгэгджээ. Өмнөх оны (128 тохиолдол) мөн үетэй харьцуулбал тохиолдлын тоо 5.9 дахин нэмэгдсэн байна.

ДӨРӨВ. Шувууны томуугийн А (H5N1) вирусын шувууны өвчлөлийн мэдээлэл:

2017 оны 01-р сарын 01-нээс 2017 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд шувууны томуугийн А (H5N1) вирусаар 3 тив (Ази, Африк, Европ) - ийн 17 улсад тэжээвэр болон зэрлэг шувуудын дунд **146565** өвчлөл бүртгэгдэж, **77879 (53.1%)** нь үхсэн байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Тэжээвэр болон зэрлэг шувуудын өвчлөл *(2017.01.01-12.31 хүртэлх)*

Тив	Улс	Өртөмхий	Өвчтэй	Үхсэн	Устгасан	Нядалсан
Ази	Бангладеш	326	190	136	0	0
	Камбожи	1027	0	500	0	0
	Хятад	81500	35000	15000	66500	0
	Энэтхэг	2358	41	41	2151	0
	Индонез	0	2169	13327	0	0
	Непал	2192	14	14	2162	0
	Малайз	26	16	15	11	0
	Вьетнам	20157	10325	5855	14302	0
	Лаос	19336	14495	14495	4841	0
Африк	Камерун	24413	21407	21407	4006	0
	Египет	0	55373	0	55373	0
	Нигери	181388	3681	3351	166727	0
	Того	35000	3600	3448	152	0
Европ	Болгар	12188	112	112	12076	0
	Франц	1320	0	120	0	0
	Югослав	0	2	0	2	0
	ОХУ	0	4	4	0	0
НИЙТ		**381905**	**146565**	**77879**	**328439**	**0**

Шувууны томуугийн А (H5N1)-ийн халдвар авсан шувуудыг тивээр нь харьцуулж үзвэл Африк тив хамгийн өндөр буюу **84061** тохиолдлын **28206** (33.5%) нь үхсэн (График 2).

График 2. Шувууны өвчлөл, үхэл хорогдол (тивээр)



2017 онд нийт 17 улсад шувууны томуугийн А (H5N1)-ийн халдвар бүртгэгдсэнээс Египет улс (Африк тив) хамгийн өндөр буюу **55373** тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдвартай шувууны 37.7% - ийг эзэлж байна (График 3).

График 3. Шувууны өвчлөл, үхэл хорогдол (улсаар)



Албан ёсны эх сурвалж:

- http://www.who.int/influenza/human_animal_interface/H5N1_cumulative_table_archives/en/index.html
- http://www.who.int/influenza/human_animal_interface/EN_GIP_20140727CumulativeNumber H5N1cases.pdf
- http://www.wpro.who.int/outbreaks_emergencies/H7N9/en/index.html
- http://www.who.int/influenza/human_animal_interface/influenza_h7n9/en/index.m
- http://www.wpro.who.int/emerging_diseases/aiweekly_465_09jan2015.pdf?ua=1
- http://empres-i.fao.org/eipws3g/#h=0

ЗӨСҮТ

МЭРГЭЖЛИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА

ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧИН ХАРИУЦСАН БАГ